

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 25 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 25132

Улаанбаатар хот

Энхсайханы Алтанзулыг Гүйцэтгэх захирлын  
үүрэг гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.7 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар санал хураасан дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Тус компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Энхсайханы Алтанзулыг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн томилж, нэгдүгээр гарын үсэг зурах эрхийг олгосугай.
2. Тус тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн хоёрдугаар гарын үсэг зурах эрхийг Бодлого, эрсдэлийн удирдлага хариуцсан захирал Баасанцэрэнгийн Ган-Одод үүгээр олгосугай.
3. Энхсайханы Алтанзулыг эрх бүхий албан тушаалтнаар бүртгүүлэх зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бүрдүүлж Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д үүрэг болгосугай.
4. Санхүүгийн Зохицуулах Хорооноос эрх бүхий албан тушаалтныг томилох зөвшөөрөл бичгээр ирсэн тохиолдолд тус өдрөөр Энхсайханы Алтанзулыг Гүйцэтгэх захирлаар томилогдсонд тооцсугай.
5. Энхсайханы Алтанзултай цалин, урамшуулал, нөхцөл, хариуцлагын хэмжээг тохиролцож, Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс гэрээ байгуулахыг ТУЗ-ийн дарга /Громов С.Б./-д үүрэг болгосугай.
6. Тус тогтоол батлагдсантай холбогдуулан харилцагч банкууд болон бусад байгууллагуудад мэдэгдэж, холбогдох гэрээ, баримт бичигт өөрчлөлт оруулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Э.Алтанзул/-д даалгасугай.
7. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 24/28 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.
8. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Т.Цацрал)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ГРОМОВ С.Б.



Буухиа даатгал: +976 7010-1990  
Даатгалын лавлах: +976 1800-1990



[www.mongoldaatgal.mn](http://www.mongoldaatgal.mn)  
insurance@mongoldaatgal.mn

2025 ОНЫ 8 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДРИЙН МОНГОЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТУЗ-ИЙН  
ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ДЭЭРХ “ЭНХСАЙХАНЫ АЛТАНЗУУЛЫГ ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧЭЭР ТОМИЛОХ ТУХАЙ” №25/32 ТОГТООЛЫГ  
БАТАЛСАН:



| № | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлzsэн |
|---|-----------------------------------|------------|------------|------------|
| 1 | Громов С.Б.                       |            |            |            |
| 2 | Сиваев А.В.                       |            |            |            |
| 3 | Б.Мөнхзул                         |            |            |            |
| 4 | Л.Таня                            |            |            |            |
| 5 | Огай Н.Ю.                         |            |            |            |
| 6 | М.Од                              |            |            |            |
| 7 | Э.Алтанзул                        |            |            |            |